



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/056/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим
хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас:70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1. Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	14

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.09.25 № 191

танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН МИНЖИТ БУЛГАН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.СОНГУУЛЬ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган сургууль нь 46,981.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, 115,064.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар бусад эх үүсвэрээс хүлээн авч бүртгэлд тусгасан, 67,186.9 мянган мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр данс бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

8426050458

Булган сумын ерөнхий боловсролын Минжит булган цогцолбор сургууль 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэж аймгийн Боловсролын газрын даргаар дүгнүүлэн 79.6 хувьтай үнэлэгдсэн байна.байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>413,959,008.04</u>	<u>269,621,533.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	294,600,810.21	187,316,667.67
312	Банканд байгаа бэлэн мөнгө	294,600,810.21	187,316,667.67
3121	Төгрөг	294,600,810.21	187,316,667.67
31211	Төрийн сангийн харилцах	294,600,810.21	187,316,667.67
33	АВЛАГА	26,776,670.40	199,013.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	26,577,657.20	-
335	Бусад авлага	199,013.20	199,013.20
3352	Хувь хүмүүсээс авах авлага	199,013.20	199,013.20
34	УРЬДЧИЛГАА	7,280,000.00	7,280,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	7,280,000.00	7,280,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,301,527.43	74,825,852.45
351	Түүхий эд материал	17,713,940.15	30,609,266.95
35110	Тусгай зориулалттай материал	16,188,800.15	29,685,944.95
35130	Эм боох материал	1,525,140.00	923,322.00
354	Хангамжийн материал	67,587,587.28	44,216,585.50
35410	Бичиг хэргийн материал	18,524,802.00	13,941,062.00
35420	Аж ахуйн материал	15,521,877.00	17,272,379.00
35440	Түлш, шатах тослох материал	6,321,778.78	-
35460	Хүнсний материал	27,219,129.50	13,003,144.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,815,844,194.94</u>	<u>1,734,087,399.30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,815,844,194.94	1,734,087,399.30
392	Биет хөрөнгө	1,711,176,794.94	1,629,419,999.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,854,167,461.00	1,854,167,461.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(719,296,650.28)	(835,385,342.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	746,860,976.58	867,696,848.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(371,026,641.78)	(449,472,670.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	441,591,611.19	442,638,519.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(295,019,052.17)	(277,100,114.82)
39217	Ном	53,899,090.40	26,875,297.40
393	Биет бус хөрөнгө	104,667,400.00	104,667,400.00
39301	Програм хангамж	605,000.00	605,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	104,337,400.00	104,337,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,229,803,202.98</u>	<u>2,003,708,932.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>36,407,528.00</u>	<u>4,878,600.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,407,528.00	4,878,600.00
413	Өглөг	36,407,528.00	4,878,600.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,968,028.00	-
4136	Бусад өглөг	31,439,500.00	4,878,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	31,439,500.00	4,495,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	383,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,193,395,674.98</u>	<u>1,998,830,332.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,193,395,674.98	1,998,830,332.62
511	Засгийн газрын оруулсан капитал	1,937,494,876.00	1,937,494,876.00
51101	Өмч: - төрийн	1,937,494,876.00	1,937,494,876.00
512	Хуримтлагдсан үр дүн	(950,434,175.71)	(1,144,999,518.07)
51210	Өмнөх үеийн үр дүн	(950,434,175.71)	(950,434,175.71)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(194,565,342.36)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,206,334,974.69	1,206,334,974.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,229,803,202.98</u>	<u>2,003,708,932.62</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	(төгрөгөөр)	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,092,312,636.15	4,464,064,144.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,586,436.15	133,576,144.80
120	Нийтлэг татварын бус орлого	145,586,436.15	133,576,144.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,586,436.15	133,576,144.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,224,700.00	757,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,079,200.00	2,405,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	102,282,536.15	130,413,644.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,946,726,200.00	4,330,488,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,469,543,500.00	3,842,384,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,469,543,500.00	3,842,384,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,915,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,915,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	477,182,700.00	479,188,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	477,182,700.00	479,188,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,055,597,990.01	4,631,605,694.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,055,597,990.01	4,631,605,694.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,901,149,988.44	4,459,565,335.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,617,824,214.75	3,094,889,683.20
210101	Үндсэн цалин	1,586,167,266.56	1,829,416,911.01
210102	Нэмэгдэл	868,980,058.19	1,109,726,492.19
210104	Урамшуулал	162,676,890.00	155,746,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,787,613.23	402,988,970.83
210201	Тэтгэврийн даатгал	222,488,941.97	279,490,928.70
210202	Тэтгэмжийн даатгал	26,175,169.64	30,944,293.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,677,290.22	16,301,909.54
210204	Ажилгүйдлийн даатгал	12,889,242.40	15,250,368.00
210205	Эрүүл мэндийн даатгал	51,556,969.00	61,001,471.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	443,749,768.43	477,050,540.25
210301	Гэрэл, цахилгаан	19,409,162.96	21,547,801.21
210302	Түлш, халаалт	412,685,533.47	426,365,039.04
210303	Цэвэр, бохир ус	11,655,072.00	29,137,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	12,745,060.00
210402	Тээвэр, шатахуун	-	12,745,060.00
2105	Нормативт зардал	88,021,497.00	123,289,018.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,184,218.00
210502	Хоол, хүнс	88,021,497.00	121,104,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,431,300.00	8,300,500.00
210604	Урсгал засвар	4,431,300.00	8,300,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,178,129.21	37,609,580.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,729,425.00	757,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,448,704.21	36,852,080.71

Минжит булган цогцолбор сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	351,157,465.82	302,691,982.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,436,703.00	61,093,625.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,589,998.00	24,819,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	247,130,764.82	216,778,957.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,448,001.57	172,040,358.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,315,070.00	171,882,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,315,070.00	171,882,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,132,931.57	158,058.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,132,931.57	158,058.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>36,714,646.14</u>	<u>(167,541,549.36)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	27,023,793.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		27,023,793.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(27,023,793.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>36,714,646.14</u>	<u>(194,565,342.36)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(987,148,822.0)	2,156,681,028.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(987,148,822.0)	2,156,681,028.7
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	36,714,646.0	36,714,646.0
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(950,434,176.0)	2,193,395,674.7
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(950,434,176.0)	2,193,395,674.7
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(950,434,176.0)	2,193,395,674.7
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(194,565,342.4)	(194,565,342.4)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,494,876.0	1,206,334,974.7	(1,144,999,518.4)	1,998,830,332.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>3,992,264,800.00</u>	<u>4,333,650,500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,538,600.00	3,162,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,538,600.00	3,162,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,303,900.00	3,162,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,224,700.00	757,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,079,200.00	2,405,000.00
120009	Бусад орлого	2,234,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,946,726,200.00	4,330,488,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,469,543,500.00	3,842,384,500.00

Минжит булган цогцолбор сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,469,543,500.00	3,842,384,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,915,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,915,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	477,182,700.00	479,188,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	479,188,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	477,182,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,930,350,270.71</u>	<u>4,440,934,642.54</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,930,350,270.71	4,440,934,642.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,785,773,399.14	4,268,894,284.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,619,723,139.50	3,073,443,024.83
210101	Үндсэн цалин	1,517,940,535.67	1,681,553,132.65
210102	Нэмэгдэл	950,648,055.73	1,214,613,098.21
210104	Урамшуулал	151,134,548.10	177,276,793.97
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	357,396,500.00	402,826,000.00
210201	Тэтгэврийн даатгал	246,658,400.00	273,922,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,684,500.00	32,226,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,842,300.00	16,112,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13,842,300.00	16,112,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	55,369,000.00	64,452,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	443,749,768.43	470,729,941.47
210301	Гэрэл, цахилгаан	19,409,162.96	21,547,801.21
210302	Түлш, халаалт	412,685,533.47	420,044,440.26
210303	Цэвэр, бохир ус	11,655,072.00	29,137,700.00
2105	Нормативт зардал	101,239,050.00	105,036,749.00
210502	Хоол, хүнс	101,239,050.00	105,036,749.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,000.00	8,300,500.00
210604	Урсгал засвар	3,300,000.00	8,300,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,683,900.00	64,554,080.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,484,300.00	757,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,199,600.00	63,796,580.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,681,041.21	144,003,988.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,005,241.21	121,760,688.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,675,800.00	22,243,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,576,871.57	172,040,358.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,443,940.00	171,882,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,443,940.00	171,882,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,132,931.57	158,058.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,132,931.57	158,058.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>61,914,529.29</u>	<u>(107,284,142.54)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	61,914,529.29	(107,284,142.54)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		294,600,810.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	294,600,810.21	187,316,667.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Минжит булган цогцолбор сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,690,887,000	4,440,776,584.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,690,887,000	4,440,776,584.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,493,486,400	4,268,894,284.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,268,553,100	3,073,443,024.8
210101	Үндсэн цалин	2,012,909,100	1,681,553,132.7
210102	Нэмэгдэл	1,203,911,600	1,214,613,098.2
210104	Урамшуулал	51,732,400	177,276,794.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	408,569,200	402,826,000.0
210201	Тэтгэврийн даатгал	277,827,000	273,922,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	32,685,500	32,226,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,342,800	16,112,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	16,342,800	16,112,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	65,371,100	64,452,300.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,888,200	470,729,941.5
210301	Гэрэл, цахилгаан	20,144,800	21,547,801.2
210302	Түлш, халаалт	421,605,700	420,044,440.3
210303	Цэвэр, бохир ус	29,137,700	29,137,700.0
2105	Нормативт зардал	124,407,800	105,036,749.0
210502	Хоол, хүнс	124,407,800	105,036,749.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,300,500	8,300,500.0
210604	Урсгал засвар	8,300,500	8,300,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,982,100	64,554,080.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	757,500	757,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	64,224,600	63,796,580.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,785,500	144,003,988.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,795,200	121,760,688.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,990,300	22,243,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,400,600	171,882,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,400,600	171,882,300.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	197,400,600	171,882,300.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,690,887,000	4,333,492,641.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,199,621,000	3,842,384,500.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,199,621,000	3,842,384,500.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	479,188,500	479,030,641.5
132001	Орон нутгийн төсвөөс	479,188,500	479,030,641.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,915,000	8,915,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,915,000	8,915,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,162,500	3,162,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	757,500	757,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,405,000	2,405,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		294,600,810.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		187,316,667.67

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,483.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 383.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг¹ залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Сурагчдын арта картын төлбөрийн үлдэгдлийг өглөгт тусгаагүй 383.6 мянган төгрөгийг бүртгүүлэв.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 16,099.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд² 1,305.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 1,294.9 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 13,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

3.1. ТӨЛБӨРИЙН АКТ

3.1.1 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүнсний материалын үлдэгдлийн хянаж үзэхэд он дамжин эхний үлдэгдлээр тайланд тусгагдсан бодитой оршин байхгүй зүйлс бүртгэлтэй байгаа 1,294.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ" гэж ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийг эрүүл, шим тэжээллэг, аюулгүй хоол, хүнсээр сургуулиас ханган үйлчлэх үйл ажиллагааг" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хоол, хүнсээр хүртээмжтэй хангах" гэсэн заалтуудыг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 АЛБАН ШААРДЛАГА

3.2.1. Анхан шатны баримтын бүрдэл, бүртгэл хөтлөлттэй холбоотой.

Илрүүлэлт: Бараа материалыг зарцуулалтыг улирал болон хагас жилээр бөөн дүнгээр гаргадаг, эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тооцоогүй, ахлах, дунд ангийн сурагчдын арта картын хоолны тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,305.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө

3.3 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Багш, ажилчдын хагас жилийн ажлыг үнэлэн захирлын 2025 оны Б/88 тушаалаар ур чадварын нэмэгдэл олгох журмыг үндэслэн 15 хүнийг 650.0-1.000.0 мянган төгрөгөөр шагнасан нийт 12,900.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.1-д "Төрийн албан хаагчид Засгийн газар болон төрийн бусад байгууллагаас олгох шагналын төрлийг тогтоох, төрийн албан хаагчийг шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн нэмэгдэл олгоходоо холбогдох журмыг мөрдөн ажиллах

3.3.2 Цалингийн урьдчилгаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны 4 болон 5 дугаар сард ажлаас гарсан багшид цалингийн урьдчилгаа олгосныг суутгаагүй, тухайн багштай холбогдох тооцоог бодоогүй 600.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох тооцоог бодож илүү олгосон барагдуулах.

3.3.3 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллого хийсэн ажлын хэсгийн тайлангаас үзэхэд хөрөнгийн тооллогоор физикийн лабораторийн Toolkit багаж дутагдсан зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д " өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалтуудтай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дутагдсан хөрөнгийг холбогдох этгээдээр төлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Минжит булган сургууль	Сурагчдын арта картын төлбөрийн үлдэгдлийг өглөгт тусгаагүй	1	383.6	1	383.6			1	383.6				
Нийт дүн		1	383.6	1	383.6			1	383.6				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Минжит булган цогцолбор сургууль	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүнсний материалын зарцуулалтыг тухай бүр тооцоогүй	1	1,305.0			1	1,305.0					
	багш Б.Булганбаярт цалингийн урьдчилгаа олгосныг суутгаагүй	1	600.0					1	600.0			
	Хөрөнгийн тооллогоор физикийн лабораторийн Toolkit багаж дутагдсан	1	-						1	-		
	Захирлын 2025 оны Б/88 тушаалаар ур чадварын нэмэгдэл олгох журмыг үндэслэн шагнасан.	1	12,900.0						1	12,900.0		
	Хүнсний материалын үлдэгдлийн хянаж үзэхэд он дамжин эхний үлдэгдлээр тайланд тусгагдсан бодитой оршин байхгүй зүйлс бүртгэлтэй байна.	1	1,294.9	1	1,294.9							
Нийт дүн			16,099.9	1	1,294.9	1	1,305.0	3	13,500.0			

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			